



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 24 өдөр

Дугаар АНЧ

Арвайхээр сум


Төсөл хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. СТАРТ сангийн санхүүжилтээр “Дэлхийн зөн” олон улсын байгууллагатай хамтран Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан, Гучин-Ус сумдад зудын хохирлыг бууруулах хүрээнд цөөн малтай малчин өрхийг хамруулан буцалтгүй тусламж, өвс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх зорилго бүхий “Цагийн хүндийг хамтдаа” төслийг хэрэгжүүлсүгэй.

2. Сумдын Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулан ажлын хэсэг байгуулж, төслийн шаардлагад нийцсэн малчин өрхүүдийг сонгож, төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг дээрх сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0102

D:My Doc. Zahiramj. Zasag darga